

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРД
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ**

2022.01.31

Сайншанд

/2022.01.13/ Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойд зориулан аймгийн ИТХ-аас Үндсэн хуулийн ач холбогдол, мөн чанар, түүний үзэл баримтлал, нэмэлт өөрчлөлтийн талаар иргэд, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж байна. Тус сургалтад 150 гаруй төрийн албан хаагчид болон иргэд хамрагдаж, шинэ Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт болоод зөв хандлага, харилцааны талаар сургалтыг зохион байгуулсан.

Мөн Үндсэн хуулийн өдөрт зориулан аймгийн ИТХ-аас “Тусгаар тогтнолын дуулал” яруу найргийн наадмыг МЗЭ-ийн Дорноговь аймаг дахь салбартай хамтран зохион байгуулж тус наадамд 3 аймгийн 27 яруу найрагч оролцсон байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй гэж заасны дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт халаагуурын асуудлыг шийдвэрлэж, эх нярайн тусламж үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Аймгийн ИТХ-ын даргын шагнал

2023 оны 01 дүгээр сард аймгийн ИТХ-ын даргын “Өргөмжлөл”-өөр 7 хүн шагнуулсан.

Аймгийн ИТХ-ын даргын захирамж

Аймгийн ИТХ-ын даргын нийт 15 захирамж гарснаас ангилбал Хүндэтгэл үзүүлэх тухай-2, Зардал батлах тухай-2, Шагнах тухай-3, Дэмжлэг үзүүлэх тухай-5, Бусад-3 захирамж баталсан байна.

Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн тушаал

2023 оны 01 дүгээр сард аймгийн ИТХ-ын нарийн бичгийн нийт 7 тушаал гарснаас ангилбал Бүтэц орон тоог батлах тухай-1, Арга хэмжээ зохион байгуулах тухай-1, Албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоох тухай-1, Үнэлгээний хороо байгуулах тухай-1, Ажилд томилох тухай-1, Ажлаас чөлөөлөх тухай-2 болно.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДРАГЫН ТАМГЫН ГАЗРААС 2023 ОНЫ 01
ДҮГЭЭР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

НЭГ: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Хүний нөөцийн чиглэлээр:

Дотоод ажил:

Аймгийн Засаг даргын Захирамж А 85, Захирамж Б 2, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын Тушаал А 8, Тушаал Б 18 батлагдсан байна. Үүнээс

аймгийн Засаг даргын 85 А Захирамжийг албан ёсны цахим хуудсанд байршуулсан. байршуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 375 албан бичиг ирснээс 15 нь хугацаатай албан бичиг ирсэн. Үүнээс 2 албан бичиг хугацаа болоогүй бусад 13 албан бичиг хугацаандаа шийдвэрлэгдсэн байна. Бусад байгууллагад 128 явуулсан албан бичиг байна.

Өргөдөл, гомдол, шагнал:

1-р сард иргэдээс аймгийн Засаг дарга, Тамгын газарт хандаж 314 өргөдөл, гомдол ирснээс:

- Бичгээр -195,
- Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс – 109,
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар болон <http://dornogovi.gov.mn/> сайт хаягаар – 3 өргөдөл санал ирсэн байна.

Өмнөх сард хүлээн аваад судлагдаж байсан 32 өргөдөлд хариуг өгч, 18 өргөдөл судлагдаж байна.

Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс ирүүлсэн 59 өргөдлийг хүлээн авч 37 шийдвэрлэн хариуг өгч, 22 нь судлагдах шатандаа байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүлээн авах утсаар 2 иргэний өргөдөл саналыг хүлээн авч судалж шийдвэрлэх хэлтэс албан тушаалтанд шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар 26 санал, лавлагаа хүлээн авч холбогдох албан тушаалтанд дамжуулан, хариуг өгөв.

Хүлээн авсан нийт өргөдөл, гомдлын 56 нь санал, хүсэлт, 3 нь талархал, 29 нь гомдол байв.

2022 онд нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Төрийн дээд шагнал алдар цол, одон, медалиар шагнуулахаар нийт 30 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэв.

Эдгээр нь:

- Ыйййё ёёññí ããáúÿàð ç¿ðãýёðÿí цолоор – 1,
- Õ°ã°ёì°ðèéí ããáúÿàíú óèààí ðóãèéí îãííгоор – 2,
- Öýðãèéí ããáúÿàíú óèààí ðóãèéí îãííгоор -,
- Æёðàí ããããñ îãííгоор – 17,
- Öýðãèéí ããáúÿàíú îãííгоор - ,
- Õ°ã°ёì°ðèéí õ¿íäÿð ìãããèиар – 9,
- Öýðãèéí õ¿íäÿð ìãããèиар – иргэнийг шагнуулахаар уламжилсан байна.

Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулахаар материал ирүүлсэн 21 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч бүртгэхэд аймгийн Засаг даргын “Жуух”-аар 7 иргэний, “Өргөмжлөл”-өөр 14 иргэний материал ирсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр 2022 онд гүйцэтгэсэн үйл ажиллагааны мэдээлэл, аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн нууцад хамаарах баримт бичиг, эд зүйлсийн 2022 оны жилийн эцсийн тооллогыг явуулж, илтгэх хуудас, баримт бичиг, эд зүйлсийн тооллогын бүртгэлийг тус аймаг дахь Тагнуулын хэлтэст хүргүүлэв.

Гадаад харилцааны чиглэлээр:

2023 онд Дорноговь аймаг, БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа консулын газартай хэрхэн харилцах, цаашид хамтын ажиллагаагаа өргөжүүлэх асуудлаар санал солилцсон.

Мэдээллийн технологийн чиглэлээр:

Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй цаг үеийн мэдээлэлтэй холбоотой 26 мэдээг албан ёсны цахим хуудас болон

Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем буюу ERP системийг ашиглах заавар зөвлөмжийг 8 байгууллагын 21 албан хаагчид өгч ажилласан.

ХОЁР: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС:

Дугаар 1 /2023/

2023.01.31

МОНГОЛ УЛСЫН ШИНЭ ҮНДСЭН ХУУЛИЙН ӨДӨР

- Шинэ Үндсэн хууль батлагдсаны ач холбогдол, мөн чанар, түүний үзэл баримтлал, нэмэлт өөрчлөлтийн талаар иргэд, албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг харьяалах салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх чиглэлийг нийт агентлаг, сумдад хүргүүлж ажилласан.
- Дүрслэх урлагаар дамжуулан сурагчдад эрх зүйн боловсрол олгох зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдын дунд “Үндсэн хуулиа мэдье” сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгуулж ирүүлсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж иргэдэд сурталчлав.
- Саран хөхөө театр, DTV телевизтэй хамтран Үндсэн хуулийн хүрээнд богино



хэмжээний шторк хийж иргэд, олон нийтэд хүргэсэн.

- Аймгийн Төв номын сан, Музей сургалт судалгааны төвтэй хамтран Үндсэн хуулийн үзэсгэлэнгийн арга хэмжээг зохион байгуулж дараах үзэсгэлэн 7 хоногийн хугацаанд гаргаж иргэд, олон нийтэд сурталчлан ажилласан. Үзэсгэлэнд Ардын Их Хурлын Депутат Б.Нямдорж оролцож Үндсэн хууль батлалцсан үеийн санал, сэтгэгдлээсээ үзэгч олонд хуваалцав.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР 2022 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫГ ХУГАЦААНД НЬ ТАЙЛАГНАЖ,
АГЕНТЛАГ, СУМДЫН ҮНЭЛЖ ДҮГНЭВ.

Аймгийн Засаг даргын үйл
ажиллагааны хөтөлбөр

Аймгийн 2022 оны жилийн хөгжлийн
төлөвлөгөөний хэрэгжилт

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн
хэрэгжилт

Аймгийн эдийн засаг, нийгмийг
хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт

Дорноговь аймгийн Стратеги
төлөвлөгөөний хэрэгжилт

**Агентлаг, сумдын 2022 оны үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлын
хүрээнд:**

- Агентлаг, сумдын ил тод байдлын тайлангийн хэлтэст хамаарах заалт,
- Нийт сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийн хэлтэст хамаарах ажил, үйлчилгээг үнэлж дүгнэн Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

ШҮҮХЭД ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧӨӨР
ОРОЛЦСОН БАЙДАЛ:

- “Жами үржих” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож захиргааны хэргийн Анхан шатны шүүхээс захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн бөгөөд тус шийдвэрийг эс зөвшөөрөн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргасан.
- Хөвсгөл сумын Засаг даргад холбогдох захиргааны хэргийн материалын татан авч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргуулсан.
- “Чандмань бар” ХХК- нь шүүхэд Давж заалдах гомдол гаргасныг хүлээн авсан.

ЗАСГИЙН ГАЗРЫН 1111-ТӨВД БОЛОН АЛБАН БИЧГЭЭР ИРГЭДЭЭС
ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

- Албан бичгээр-2, Засгийн газрын 1111-төвд -18 нийт 20 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч ажиллагаа хийж хугацаанд нь шуурхай шийдвэрлэн ажиллав.
- ✓ Хугацаа хэтэрсэн, хариу өгөөгүй өргөдөл гомдолгүй ажиллаж байна.

**ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР 2023 ОНД ХИЙГДЭХ, АЖИЛ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТҮҮД**

- Хууль, эрх зүйн хэлтсээс 2023 онд дэвшүүлэх зорилт болон тухайн жилд хэрэгжүүлэх цаглавар төлөвлөгөөг гарган ажиллаж байна.
- Хууль, эрх зүйн хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төрийн жинхэнэ албан хаагчдын 2023 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.
- Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2023 онд байгуулах гэрээний төсөлд санал хүргүүлж, батлагдсан гэрээг хүлээн авч түүнийг үндэслэн салбарын чиглэлээрх төлөвлөлтүүдийг гаргасан.
- Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.
- Үндэсний аюулгүй байдлын болон Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөг тус тус боловсруулсан.
- Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгах саналыг гаргаж хүргүүлсэн.
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг болон гэр бүл, хүүхдийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.
- Аймгийн Засаг даргаас Хууль, эрх зүйн хэлтсийн харьяа агентлагийн дарга нартай 2023 онд хамтран ажиллах гэрээний төслийг бэлтгэсэн.
- Аймгийн Засаг даргаас Сумдын Засаг дарга нартай байгуулах 2023 онд хамтран ажиллах, төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний төсөл Хууль, эрх зүйн салбараас нийлүүлэх ажил, арга хэмжээний талаарх саналыг гаргаж хүргүүлсэн.

**АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

- Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 2022 онд ХАСХОМ мэдүүлэх албан хаагчид болон албан тушаалын жагсаалтыг сум бүрээс гаргуулан авч нэгтгэн хүргүүлсэн.
- Эрх бүхий албан тушаалтнуудыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан давтан сургалтад хамруулсан. Мөн ЭБАТ-уудад зөвлөгөө өгч, хуулийн хугацаанд ХАСХОМ-оо мэдүүлэх талаар хяналт тавин ажиллаж байна
- Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах талаар бүх сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт чиглэл хүргүүлсэн.
- Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр тайлагнахаар хэлтсүүдээс мэдээллийг авч нэгтгэх ажлыг зохион байгуулж байна.

**СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙН БҮРТГЭЛ ХӨТЛӨН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ
ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА**

№	Он сар өдөр	Сургалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллага / он сар	Сургалт, мэдээллийн сэдэв	Хамрагдсан хүний тоо	Хугацаа
---	-------------	--	---------------------------	----------------------	---------

		өдөр/				
		2023 оны 01 дүгээр сард				
1	01/03	Сумдын ЗДТГ-ын дарга, багийн Засаг дарга, бүртгэл мэдээллийн ажилтан	“Шинээр хэрэгжиж эхлэх хууль, эрх зүйн мэдээлэл “ (ХАСХОМ), (ХАСХУМ), авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж	120	80 минут	
2	01/05	Соёлын удирдах ажилтнуудад	Шинээр хэрэгжиж эхэлсэн хууль. Эрх зүй	25	40 минут	
3	01/13	Нийтлэг үйлчилгээний газрын албан хаагчдад	Үндсэн хуулийн ойлголт	25	40 минут	
4	01/13	АЗДТГ-ын албан хаагчдад	Үндсэн хуулийн ойлголт	20	30 минут	
5	01/15	Сумдын Засаг дарга нар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Ман эмнэлэг	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон түүнтэй дагалдах бусад хууль тогтоомж, отрын бүс нутгийн холбоотой асуудлаарх эрх зүйн сургалт	25	40 минут	
6	01/20	АЗДТГ-ын алба хаагчдад	Шинээр батлагдсан хууль тогтоомж	30	30 минут	
НИЙТ 6 УДААГИЙН СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛЭЭР ХҮНД 4 ЦАГ 30 МИНУТЫН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХҮРГЭСЭН.				145	4 цаг 30 минут	

**ШИНЭЭР ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСЭН ЭРХ ЗҮЙН АКТЫН ТАЛААР СУРГАЛТ,
МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ТОГТМОЛ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА.**

- 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн эрх зүйн актуудын талаар мэдээлэл бэлтгэж аймгийн ЗДТГ-ын албан хаагчид, сумдын ЗДТГ, багийн Засаг дарга, хэсгийн ахлагч, сумдын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтнүүд, сумдын Соёл, спортын төвийн албан хаагчдад хүргэснээс гадна цахим орчинд байршуулан иргэдийг мэдээллээр хангаж ажилласан.
- Төрийн мэдээлэл сэтгүүлийн 3 дугаарыг хүлээн авч цахим санд бүртгэл хийсэн.
- Түүнчлэн 7 хоног бүр эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд шинээр орсон эрх зүйн актын талаарх мэдээллийг товч байдлаар бэлтгэн аймгийн ЗДТГ-ын албан хаагчид болон сумдын Засаг дарга, мэргэжилтнүүдийг мэдээллээр хангаж хэвшээд байна.

**ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ХАМТРАН
ЗОХИОН БАЙГУУЛАВ.**

Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд иргэд, олон нийт, агентлаг, сумдаас санал авах,

хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран хэрэгжүүлсэн.

ЗАМЫН-ҮҮД СУМЫН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТНУУДАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГЧ АЖИЛЛАВ

Архивын тасгаас 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газартай хамтран төрийн байгууллагын удирдлага, архив, бичиг хэргийн ажилтнуудад мэргэшүүлэх сургалт зохион байгуулав. Сургалтад нийт 42 төрийн албан хаагч оролцож мэдлэгээ дээшлүүллээ.

Сургалтаар “Байгууллагын удирдлага, төрийн албан хаагчдын архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр хэрэгжүүлэх чиг үүрэг”, “Баримт бичгийн стандартыг хэрэгжүүлэх арга зүй”, “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”, “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах арга зүй”, “Хадгаламжийн нэгж бүрдүүлэх арга зүй”, “Монгол хэл бичгийн дүрэм” зэрэг сэдвээр хичээл зааж, санал солилцов.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ЦАХИМ ХУУДАС 8290 ИРГЭНД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭСЭН.

- Хууль, эрх зүйн хэлтэс цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэх ажлыг тогтмол хэрэгжүүлж байгаа бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын үзүүлэлтээр нийтлэлийн хүртээмж 8290, нийтлэлтэй харилцах 2100, нийтлэлийг шэйрлэсэн 77, хариу үйлдэл үзүүлсэн 282 хүн байна.

ЗАХИРАМЖ, ТУШААЛЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛИЙГ ХЯНАХ, АЛБАН ХЭРЭГ, ХӨТЛӨЛТИЙН СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ:

- 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар аймгийн ЗДТГ-ын алба хаагчдаас боловсруулсан 78 захирамж, 16 тушаалыг хянаж тухай бүр зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.
- Улаанбадрах сумын Засаг даргаас 2022 оны 4 дүгээр улиралд батлан гаргасан 10 захирамжлалын баримт бичгийг хянаж хариу хүргүүлсэн.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛСЭН БАЙДАЛ

- Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, мэргэжилтнүүдээс нийт 9 иргэнийн хүсэлтийн дагуу утсаар болон биечлэн уулзаж хууль, эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн.
- Сайншанд сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулах, орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгө, шугам сүлжээний засвар үйлчилгээ, орон сууцны хэвийн байдлыг хангахад мэргэжлийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээ, дундын өмчлөлийн эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт хэвийн үйл ажиллагааг хангахад байнгын хяналт тавих, хамтран ажиллах үйл ажиллагаанд үүсэх талуудын харилцааг зохицуулах Сайншанд сумын Засаг дарга, Чандмань-Илч ОНӨХХК, Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж буй сууц өмчлөгчдийн холбооны хооронд байгуулах гурван талт гэрээний төслийг боловсруулсан. /хууль, эрх зүйн холбогдох зөвлөгөө мэдээллээр хангасан/

ХИЛ ХАМГААЛАХ ТУСЛАХ ХҮЧНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДТЭЙ ЦАХИМ УУЛЗАЛТ, ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

- Аймгийн ИТХ-ын дарга Ганзориг 2023 оны 01 дүгээр сарын 25-ы өдөр “...өвөлжилд хүндэрч малчид малаа хил рүү байгалийн нөхцөл байдлаас шалтгаалан уруудуулах, хилийн тор руу мал орох, үүнээс шалтгаалан малчдад хүндрэл үүсэж байна. Мөн хилийн тор эвдэрсэн үүнийг аймаг, сум, иргэдийн оролцоотойгоор засаж сайжруулах, энэ талаар хил хамгаалах туслах хүчний зөвлөл анхаарах...” талаар АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст мэдээлэл, чиглэл өгсний дагуу мэдээллийг аймгийн Засаг даргад хүргэн чиглэл авч цахим хурлыг 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан.
- Цахим хуралд Аймгийн Засаг даргын орлогч Г.Март, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, холбогдох хэлтэс, Хилийн цэргийн 0108, 0129, 0168 дугаар ангийн штабын дарга, Өргөн, Эрдэнэ, Хатанбулаг, Хөвсгөл, Замын-Үүд сумдын Засаг дарга болон багийн засаг дарга нар оролцсон.
- Аймгийн Засаг даргын орлогч Г.Март Хил хамгаалах байгууллага болон сумдын Засаг дарга нарын мэдээллийг сонсож тухай бүр үүссэн нөхцөл байдлыг арилгах арга хэмжээ авч, туслах хүчний зөвлөлийн гишүүд нь иргэдийг мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах, үл ойлголцол гаргахгүй ажиллах, хилийн тор, шонг засаж сайжруулах талаар эдийн засгийн тооцоо судалгаа гаргаж ирүүлэх талаар чиглэл өглөө.

“ИРГЭНИЙ НИЙГМИЙН ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтарсан төлөвлөгөө боловсруулан батлуулж дараах үйл ажиллагааг зохион байгуулж байна.

- Иргэний нийгмийн байгууллагын өдрийг сурталчлан таниулах, иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор зурагт хуудас бэлтгэж цахимд байршуулах, сумдад түгээж ажиллах талаар сумдын Хууль, эрх зүйн мэргэжилтнүүдэд чиглэл өгсөн.
- Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах
- Иргэний нийгмийн байгууллагыг судалгааг салбар, салбараар нь гаргах, тэдгээрийг чадавхжуулах, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ИНБ-тай хамтран сургалт зохион байгуулах
- Иргэний нийгмийн байгууллагуудын дунд төслийн уралдаан зарлах /5-10 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт олгож хамтран ажиллах/

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ ОРОН ТОО ШИНЭЧЛЭН БАТЛАГДАЖ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭСТ

- Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн асуудал хариуцсан мэргэжилтэн, улсын байцаагч ажиллах нөхцөл бүрдлээ.

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эрүүл мэндийг дэмжих бүлгэмтэй хамтран Сайншанд сумын 2, 5, 9 дүгээр цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 109 хүүхдүүд 58 эцэг эхийн төлөөлөлд нийт 167 хүнд Амны хөндийн эрүүл мэнд сэдвээр сургалт зохион байгуулав.

Дорноговь аймгийн Ахмадын хороотой хамтран 1,2,3,4,6,7,8-р багийн 55 ахмад настанд □□“Үений үрэвсэл”, “Тулай ” өвчнөөр сургалт явуулав.

Эрүүл мэндийн байгууллагуудын 2023 оны хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2830.0 сая төгрөгийн 31 багц, Сумын эрүүл мэндийн төвүүдийн 274.0 сая төгрөгийн 26 багц бүхий нээлттэй тендерүүдийн нээлтийг хийж, үнэлгээний шатандаа явагдаж байна.

Шинээр боловсруулан батлагдах “Усчин, гоо сайхны газар мөрдөх үлгэрчилсэн дүрэм”-д 2 санал, “Хоол үйлдвэрлэлийн газарт мөрдөх эрүүл ахуйн үлгэрчилсэн дүрэм”-д 1 санал, “Хог хаягдлын менежмент шалгах хяналтын хуудас”-д 7 санал, “Сум тосгон, сум дундын эрүүл мэндийн төвийн оношилгоо эмчилгээний чанар аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-д 1 санал, Өрхийн эрүүл мэндийн төвийн оношилгоо эмчилгээний чанар аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-д санал, “Тамхи хяналтын журам”-д 1 санал тус тус боловсруулж, ЭМЯ-ны СХГ-т цахимаар хүргүүлсэн.

Иргэний хүсэлтээр “Үйлчилгээний барилга”-ын ажлын зураг төсөлд эрүүл ахуйн баталгаажуулах хяналт хийж, газрын даргын 2023 оны 98 дугаартай албан бичгээр зөвлөгөө өгсөн.

МХГ-аас чиг үүргийн дагуу шилжин ирсэн 5 албан хаагчийн Албан тушаалын тодорхойлолт боловсруулж, батлуулахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, Улсын байцаагчийн эрх олгох тухай хүсэлт холбогдох материалыг ЭМЯ хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Замын-Үүд суманд шинээр ашиглалтад орсон Замын-үүд боомтын цогцолборын барилга, Чөлөөт бүсэд шинээр ашиглалтад орсон үйлчилгээний барилга байнгын ашиглалтад оруулах комисст ЭМГ-аас Эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч ажиллаж, үүрэг чиглэл өгч ажилласан.

ЭМГ-аас Аймгийн нэгдсэн эмнэлэгт 2 удаа дэмжлэгт хяналт хийж зөвлөгөө өгч ажилласан.

Эрүүл мэндийн газраас салбарын хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж, хүний нөөцийн хууль эрхзүй нийгмийн хамгааллын чиглэлээр хийгдэх ажлын 3 төлөвлөгөөг танилцуулан, түүний хэрэгжилтийг хангуулж тайлан хэрхэн гаргах талаар чиглэл өгч, нийгмийн хамгааллын төлөвлөгөөнд оруулах санал хэлэлцэж, тэтгэмж шагналын материал хүлээн авах шийдвэрлэх явцын төлөвлөлтийн талаар мэдээлэл хийлээ. Сургалтад 14 байгууллагын 15 хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагч оролцсон .

ЭМС тушаалаар батлагдсан ЭМХТ, АШУҮИС-ийн НЭМС хамтарсан ажлын хэсэг Дорноговь аймагт 2023-01-23 наас 5 хоног ажиллав. “Хүний нөөцийн нийгмийн хамгааллын суурь судалгаа”-г 8 аймагт сонгон хийж байгаа бөгөөд Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-үүд сумын нэгдсэн эмнэлэг, Хатанбулаг СЭМТ, Агатова ӨЭМТ -үүд түүврийн аргаар уг судалгаанд хамрагдсан.

Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвөөс ирүүлсэн “Цаг үеийн нөхцөл байдалд тохирсон нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах зөвлөмж”-ийн хэрэгжилтийг хангаж тайланг хүргүүлэв. Коронавируст халдвар, томуу, томуу төст өвчин, угаарын хий, химийн бодисын хордлого, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, сурагчдын амралтын үеэр хүүхдийн аюулгүй байдлыг хангах гэх мэт чиглэлээр сурталчилгааг эрчимжүүлэн 70 зөвлөмж мэдээллийг цахим сүлжээнд байршуулж 37843 хандалт авсан.

2022 оны 05 сараас эхэлсэн эрүүл мэндийн “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ оношилгоо”-нд аймгийн хэмжээнд 19734 иргэн хамрагдсан нь

хамрагдвал зохих хүн амын 27.4%-ийг эзэлж байна. Үзлэгт хамрагдсан хүн амын 71.2% (14051)-ийг 0-17 насны хүүхэд, 28.8% (5683)-ийг 18-аас дээш насны хүн ам байна.

ЭМС-ын 2023 оны 02 албан даалгаврын хүрээнд дархлаажуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааг ажиглалт хийх болон анхан шатны бичиг баримтын хөтлөлтийг үнэлэх байдлаар хяналт хийж байна. Талст зам ӨЭМТ-ийн дархлаажуулалтын үйл ажиллагааг 63%-тай гэж үнэлэн арга зүйн зөвлөгөө өгсөн. Ирэх 7 хоногт бусад нэгжүүдэд үнэлгээ хийхээр төлөвлөсөн.

Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх “Хүүхэд-аюулгүй орчин” аяны хүрээнд Сайншанд сумын 4, 14-р цэцэрлэгийн эцэг эхчүүдэд сургалт зохион байгууллаа.

Сайншанд сумын 7 багийн ахмад настнуудад “Нойргүйдэл” “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн халдварт, сүрьеэгийн тасаг, БЗДХ-ын кабинетийн эмч мэргэжилтнүүдэд 2022 оны ажлыг дүгнэн халдварт өвчний статистик мэдээлэл танилцуулж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар уулзалт ярилцлага зохион байгуулсан

ХӨСҮТ-өөс 2023 оны 1-р улирал хэрэглэх 9,0 сая төгрөгийн вакцин дагалдах хэрэгслийг татан авч, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тараасан.

ХӨСҮТ-ийн ТХТН-ээс зохион байгуулсан цахим хуралд сууж ТТӨ-ний нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх төлөвлөлтэй танилцаж арга зүйгээр хангагдсан

“Алсын зайн хэм хяналтын төхөөрөмж суурилуулах” арга зүйн сургалтанд хамрагдаж төхөөрөмжийг вакцины агуулахад суурилуулсан.

ЭМХТ-д аймгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж хүргүүлэв

Анхан шатны шинэ залуу эмч, сувилагч нарыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн тасаг, Дүрс оношилгооны кабинетэд ажлын байрны дадлагажих сургалтад хамруулах ЭМГ-ын 2023 он А10 дугаар тушаал гаргаж, хүргүүлэв

ЭМХТ-өөс зохион байгуулсан магадлан итгэмжлэлийн цахим хуралд оролцож, 2022 оны ажлыг дүгнэж, цаашид анхаарах асуудлууд, 2023 оны төлөвлөлтийг хэлэлцүүлж, санал солилцов

ТЗК-ийн хуралд оруулах төсөл, материалыг хүлээн авч, бэлтгэл хангаж, 2023 оны 01 сарын 27-ны 14 цагт хуралдахаар товлосон

Талст зам ӨЭМТ-д ажлын хэсгээр дэмжлэгт хяналт хийж арга зүйн заавар чиглэл өгөв

2023 онд хэрэгжүүлэх Сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөнүүдийг боловсруулан ЭМБ-дад хүргүүлсэн

СОЁЛ УРЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Дорноговь аймгийн соёл урлагийн байгууллагуудын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгийн тайлан болон 2023 оны төлөвлөлтийн талаар хэлэлцэх уулзалт зохион байгуулж, Аймгийн Соёл, урлагийн газар, мэргэжлийн урлагийн байгууллага Саран хөхөө театр, Музей сургалт судалгааны төв, Төв номын сан, 14 сумын Соёлын төв болон Соёл, спортын төвүүдийн нийт 25 албан хаагч, ажилтнууд оролцов. Монгол улсын Соёлын яамны зөвлөх баг тус салбарын хөгжлийн стратеги, төлөвлөгөөний боловсруулалтад зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажилласан.

Монгол Улсад шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойг тохиолдуулан Соёл урлагийн газар, мэргэжлийн урлагийн байгууллага Саран хөхөө театр, Музей сургалт судалгааны төв, Төв номын сан хамтран лектор Шинэбаярыг урьж "ЗҮРХ СЭТГЭЛ-ЗӨВ ХАРИЛЦАА, ХАНДЛАГА" сэдвээр сургалт зохион байгууллаа. Мөн Дорноговь аймаг дахь Хүний эрхийн үндэсний комиссоос "Хүний эрхийн байгууллага"-ийн үйл ажиллагааны

талаарх сургалт, мэдээлэл өглөө. Тус сургалтад 40 гаруй албан хаагч, уран бүтээлчид оролцлоо.

Монгол Улсад шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ой, Монголын Зохиолчдын Эвлэлийн Дорноговь аймаг дахь салбарын нээлтийн үйл ажиллагаанд зориулсан "ТУСГААР ТОГТНОЛЫН ДУУЛАЛ" яруу найргийн наадмыг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Соёл урлагийн газар хамтран зохион байгууллаа. Тусгаар тогтнолын дуулал яруу найргийн наадамд 24 яруу найрагч оролцож 3 үе шаттайгаар шилдгийн шилдгээ тодрууллаа.

- Тэргүүн байр-МЗЭ-ийн шагналт яруу найрагч А.Байгалмаа
- Дэд байр-Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, МЗЭ-ийн шагналт яруу найрагч А.Лхагва
- Гутгаар байр-МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Б.Аасүрэн
- Тусгай байр-Монголын зохиолчдын "Хутагтын Хурмаст тэнгэр" төвийн гишүүн, яруу найрагч Д.Эрдэнэзулай

Тусгай байр-МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Б.Баярмөнх

Дорноговь аймгийн Соёл, урлагийн газрын зөвлөн туслах ажлын баг 2023 оны 01 дүгээр сарын 04-ны өдөр мэргэжлийн урлагийн байгууллага Саран хөхөө театрт ажиллалаа. Уран бүтээлчид, албан хаагчдыг ажлын байран дээр сургах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол улсын Соёлын яамны зөвлөх баг болон Соёл, урлагийн газрын мэргэжилтнүүдийн зүгээс Саран хөхөө театрын үйл ажиллагаанд зөвлөмж, чиглэл өгч ажиллалаа.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан ХАСХОМ мэдүүлэг гаргах сургалтад ЭБАТ хариуцсан мэргэжилтэн болон ХАСХОМ мэдүүлэг гаргах 4 албан хаагч хамрагдсан.

Соёл урлагийн газар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн нэгж 3 байгууллага болон сумдын соёлын төвүүдийн саналыг хүлээн авч байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсрууллаа.

Соёл урлагийн салбарын залуучуудын холбоо хуралдаж 2023 оны төлөвлөгөөгөө боловсруулан баталлаа.

Сэвжидийн нэрэмжит Улсын өсвөрийн бүжигчдийн 16-р наадмыг зохион байгуулах салбар зөвлөл хуралдаж наадмын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсрууллаа.

Соёл урлагийн газрын баяр наадмыг зохион байгуулах салбар зөвлөл хуралдаж зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөгөө хэлэлцлээ.

САРАН ХӨХӨӨ ТЕАТР

Аймгийн Саранхөхөө театр нь 8 төрлийн үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, үзвэр, урлагийн үйлчилгээг 900 үзэгчдэд хүргэж ажиллав.

Үүнд:

- 2023 оны 01 сарын 25-нд 19 цагаас дуучин Дашнямын аялан тоглолт тус театрын үзвэрийн танхимд 365 үзэгчдэд тоглогдсон.
- 2023 оны 02-р сарын 02-нд МУСТА Н.Мөнгөншагайгийн “Хайрламаар сайхан” аялан тоглолт тоглогдсон.
- “Ажлын байр, эрүүл мэнд”-ийн дасгалыг Дорноговь аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороо тус театрын бүжиг ангийн хамтран зохион байгуулсан.

МУЗЕЙ СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТӨВ

Монгол улсад Шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойг угтан аймгийн Төв номын сантай хамтарсан номын үзэсгэлэн болон сурагчдын дунд зарласан Гар зургийн уралдаанд оролцогчдын үзэсгэлэн нээгдсэн. Үзэсгэлэнд 22 гар зураг дэлгэгдэн, 43 хүүхэд, 30 том хүн үзэж сонирхсон.

Бүх нийтэд соёлын боловсрол олгох зорилгоор Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төвтэй хамтран Яруу найрагч Д.Эрдэнэзулайгийн “Авгалдайн суурин” номын нээлт, уншлагыг зохион байгуулж, арга хэмжээнд 25 хүн оролцсон.

“Дорноговьд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг 01 сарын 23-ны өдөр зохион байгуулж, үзэсгэлэн худалаанд 6 бүтээлч үйлдвэрлэгч оролцсон.

2023 оны 01 сард аймгийн Музей, сургалт судалгааны төвөөр хүүхэд-183, том хүн-17, гадаад иргэн-4 тус тус музейгээр үйлчлүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газарт байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хүргүүлэв.

ТӨВ НОМЫН САН

2022 оны 1 дүгээр сард Төв номын сан 354 уншигчдад үйлчилсэн. Танхимаар 922 ном, гэрээр 130 ном олгосон. Зөөврөөр 100 уншигчдад үйлчилж, 160 ширхэг номоор үзэсгэлэн гаргалаа.

Сурагчдын амралтыг тохиолдуулан хүүхдийн зохиолч Л.Мөнхбаттай хамтран хүүхдүүдэд үлгэр тууль, дэлхийн сонгодог хүүхдийн зохиолоор ярилцлага өрнүүлж 15 хүүхэд оролцсон.

СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Биеийн тамир, спортын газрын жүдо бөх, чөлөөт бөх, бокс, шатар, сагсан бөмбөг, волейболын дугуйлан, шагай харваа, фитнес хэвийн хичээллэн ажиллаж байна.

Нөхөрлөл лигийн 3 дугаар тойргийн тоглолт 2023 оны 01 дүгээр сарын 17, 24, 31-ний өдрүүдэд мөн тэмцээн болов.

Байгууллагын албан хаагчидтай 2023 онд ажиллах хөдөлмөрийн гэрээ болон албан тушаалын тодорхойлолтыг шинээр боловсруулан, байгууллагын дарга нийт албан хаагч нартай хөдөлмөрийн гэрээг 01 дүгээр сарын 25-ны өдөр байгуулан ажиллав.

Спорт цогцолборын 50 метр орчмын цэвэрлэгээг албан хаагчид хийж ажиллалаа.

Спорт цогцолборын заалны шалны будаг, лакны ажлыг хийж гүйцэтгэж, тэмцээн уралдаан зохион байгуулах боломжийг бүрдүүллээ.

Сагсан бөмбөгийн оюутны лигийн анхны аялан тоглолт Дорноговь аймгийн Сайншанд суманд 2023 оны 01 дүгээр сарын 14-ний 14.00 цагт Спорт цогцолборт боллоо. 1995 онд анхны Оюутны лигийн тэмцээн явагдаж эхэлснээс хойш 28 жилийн хугацаанд анх удаа Оюутны лигийн улирлын албан ёсны тоглолтууд хөдөө орон нутагт явагдсан нь Дорноговь аймаг байлаа. Шинэ хуудсыг нээн аялан тоглолтонд МУИС Hi-Pay Шонхорууд, Роял Gulls, Мон Алтиус ДС-ийн Lions, ОУУБИС Унаганууд багийн тамирчид, багш дасгалжуулагч нар оролцлоо.

Сайншанд суманд 01 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд холимог насны боксчдын олон хотын нээлттэй тэмцээн болж, 150 хүхэд оролцож, авхаалж самбаа, хурд хүчээ сорьлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдах нийтийн хөлбөмбөг төслийн хүрээнд Монголын Хөлбөмбөгийн Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргаар ахлуулсан баг Зүүн бүсийн уулзалтыг Дорноговь аймагт 01 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд хийлээ. Уг уулзалтаар орон нутгийн удирдлагуудтай уулзаж, нийтийн хөлбөмбөг, аймгийн Хөлбөмбөгийн холбооны үйл ажиллагааны талаар санал солилцож, 21 аймгийн аварга шалгаруулах хөлбөмбөгийн тэмцээнийг аймагт зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

“Олимпын боловсрол ба бие бялдрын хүмүүжил” болзолт уралдааны талаар мэдээлэл олгох уулзалт 01 дүгээр сарын 17-ны өдөр цахимаар болсон бөгөөд байгууллагын дарга, усан спортын дасгалжуулагч нар хамрагдлаа.

Спорт цогцолборт 01 дүгээр сарын 20-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дундах сагсан бөмбөг, дартсын тэмцээн зохион байгуулагдав.

Хөлбөмбөгийн ууган мастер Г.Банзрагчийн нэрэмжит футзалын насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн Спортын ордонд 01 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд болов. Тэмцээнд ЦТС. Замын-үүд депо, Сайншанд депо, Мараахай транс, Фс Түмэн-Од. Ахмадын баг. Айраг. Фриендс гэсэн 9-н багийн 100 гаруй тамирчид гурван зоонд орж өрсөлдснөөс: 1-р байрыг ЦТС, 2-р байрыг Айраг сум, 3-р байрыг Замын-Үүдийн баг тус тус эзэллээ.

Спорт цогцолборт 01 дүгээр сарын 21-ний өдөр Замын 4 дүгээр ангийн албан хаагчдын дундах спортын арга хэмжээ болов.

Спортын ордонд 01 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд Софт волейболын ахмадын нээлттэй тэмцээн болж, 15 багын 80 гаруй тамирчид оролцлоо. эрэгтэй 1-р байр Андууд баг, 2-р байр Хөнгөн бөмбөг 2 баг, 3-р байр Арын БОС баг, Эмэгтэй 1-р байр Цоглог баг, 2-р байр Цэцэрлэг баг, 3-р байр Айраг баг тус тус шалгарлаа.

Спорт цогцолборт 01 дүгээр сарын 29-ний өдөр Сар шинийн харвааны сорилго тэмцээнд оролцохоор ахмад болон залуу шагай харваачид бүтэн өдрийн турш бэлтгэл хийв.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын уугуул Монголын боксын холбооны дэд ерөнхийлөгч В.Ганзоригийн нэрэмжит "Сайншанд-2023" холимог насны боксчдын аварга шалгаруулах олон хотын нээлттэй тэмцээн 01 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд болж өндөрлөлөө.

Багийн дүнгээр:

- 1 байр Дорноговь аймаг
- 2 байр Радианс боксын клуб
- 3 байр Өмнөговь аймаг тус тус шалгарлаа.
- Тэмцээний шилдэг эрэгтэй тамирчнаар О.Мөнх-Эрдэнэ /ЕБ-ын 1-р сургууль/, эмэгтэй шилдэг тамирчнаар Б.Амин-Эрдэнэ / ПТК /
- Өсөх ирээдүйтэй тамирчнаар Г.Номтойбаяр /ЕБ-ын 1-р сургууль/
- МУГТ У.Мөнх-Эрдэнийн нэрэмжит цомоор О.Түвшинзаяа /Радианс /
- Шилдэг шүүгчээр Р.Чинбат нар шалгарлаа.

2023 оны Жюү жицүгийн улсын аварга шалгаруулах тэмцээн амжилттай болж өндөрлөлөө. Тус тэмцээнд 490 тамирчид 96 багц медалийн төлөө өрсөлдөн өсвөр үе, залуучуудын ангилалын медальтнууд эцэслэн тодорч Дорноговь аймгийн Хилэнц клубын өсвөрийн тамирчид амжилттай оролцлоо.

[#Өсвөр_үе:](#)

- Саарал бүсний 32 кг Г.Энгүүн Алтан медаль
- Цагаан бүсний 40 кг Б.Сарангоо Хүрэл медаль
- Цагаан бүсний 57 кг Н.Өэлүн Хүрэл медаль
- Цагаан бүсний 68 кг Ч.Мишээл Мөнгөн медаль
- Цагаан бүсний 34 кг А.Отгон-Эрдэнэ Алтан медаль
- Цагаан бүсний 60 кг Т.Сумъябазар Хүрэл медаль
- Цагаан бүсний 41 кг Б.Төгс-Эрдэнэ Хүрэл медаль
- Цагаан бүсний 48 кг М.Азжаргал Хүрэл медаль
- Цагаан бүсний 50 кг Н.Төгсжаргал Хүрэл медаль
- Цагаан бүсний 55 кг Г.Алтаншагай Алтан медаль
- Цагаан бүсний 50 кг Э.Мөнхбаатар Алтан медаль
- Цагаан бүсний 50 кг Х.Амарзаяа Хүрэл медаль
- Цагаан бүсний kids 36 кг Г.Энхрийлэн Хүрэл медаль
- Цагаан бүсний 62 кг С.Сүлд-Эрдэнэ Алтан медаль

[#Залуучууд:](#)

- Цэнхэр бүсний 73 кг Т.Сүхбат Мөнгөн медаль
- Цэнхэр бүсний 56 кг Г.Билгүүн Хүрэл медаль

-Цэнхэр бүсний 80 кг Б.Алимцэцэг Хүрэл медаль
-Цагаан бүсний 57 кг О.Оюунбаяр Хүрэл медаль
-Цагаан бүсний 94 кг У.Мөнх-Эрдэнэ Мөнгөн медаль

Дээлтэй шагайн харваа-2023 үндэсний шагайн харвааны тэмцээн зохион байгуулагдлаа. Дорноговь аймгийн Шагайн салбар холбооноос санаачлан "Дээлтэй шагайн харваа -2023 " үндэсний шагайн харвааны тэмцээнийг зохион байгууллаа. Энэхүү тэмцээний гол зорилго нь үндэсний дээл хувцсаа зөв сайхан өмсөхөд үлгэрлэх, түүнийг өвлөн тээж яваа харваачид үндэсний хувцастай харваж сурахад оршиж байгаа юм. Тэмцээнд Дорноговь, Өмнөговь, Дундговь, Төв, Говьсүмбэр аймгийн нийт 41 багийн 300 гаруй харваачид оролцсоноос: Тэргүүн байранд МУМ Г.Наранбат ахлагчтай "Гуа орд" баг, дэд байранд АГМ У.Өнөржадамба ахлагчтай Даланжаргалан сумын баг, гутгаар байранд МУМ П.Пүрэвцэрэн ахлагчтай "Амин болор" баг, тусгай байранд залуу харваач Т.Сансар ахлагчтай Айраг сумын багууд тус тус шалгарлаа.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Нэг. Өсвөр үе, хүүхдийн хөгжил, гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Хүүхдийн авьяас, оюун билгийг нээн олж, төгөлдөржүүлэн хөгжүүлэх зорилгоор хичээллүүлж буй дугуйлан, секцийн үйл ажиллагааг жигдрүүлэх: Хүүхэд хөгжлийн төвийн дэргэдэх уран зураг, уран нугаралт, шатар, ятга, англи хэл, монгол бичиг, рубик шооны 7 төрлийн дугуйлангийн гарын авлага, танилцуулгыг бэлтгэн цахим хуудсаар олон нийтэд хүргэсэн. Цахим хандалтын тоо 12.070. Эцэг эхчүүдэд эцэг, эх байх хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагыг ойлгуулах чиглэлээр эцэг эх, хүүхэд багачуудад 5 төрлийн зөвлөмж, постерыг олон нийтэд хүргэж цахим хандалтын тоо 6850. Түүнчлэн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд мөрдөх дотоод журам, дугуйлан хичээллүүлж буй багш нартай байгуулах "Хамтран ажиллах" гэрээний төслийг боловсруулсан.

Монгол бичгийн "Сайхан бичигтэн", "Миний эх орон" гар зургийн уралдааныг цахим хуудсаар зарлах: Монгол өв уламжлал, ёс заншил, хэл соёл, үндэсний бахархлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоо монгол бичгийн "Сайхан бичигтэн" "Миний эх орон" гар зургийн уралдааныг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр хүртэл цахим хуудсаар зарласан. Тус уралдаанд Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчид хамрагдах бөгөөд насны ангилал тус бүр эхний 3 байрыг шалгаруулна

"Анхаарлаа нэмье" видео бичлэгийг бэлтгэж олон нийтэд хүргэх: Лидер сурагч академиас зайлшгүй шаардлагатай үед гэрлэн дохиогүй гарцаар зам гарахдаа хүмүүсийн мэддэг хэрнээ хайхрамжгүй ханддаг аюулгүйн дүрмүүдийг тайлбарласан "Анхаарлаа нэмье" видео бичлэгийг цахим хуудсанд байршуулсан. Тус бичлэгээрээ жолооч, явган зорчигч аль аль нь "Хариуцлагатай, Анхааралтай" байхыг уриалсан. Цахим хандалтын тоо 3800.

"Уран жиргээ" уран уншлагын аваргыг шалгаруулах тэмцээний удирдамжийг бэлтгэж олон нийтэд хүргэх: Дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг зохиол бүтээлийг хүүхэд багачуудад таниулах, сурталчлах, тэдний дунд уран уншлагын урлагийг хөгжүүлэх зорилгоор аймгийн шилдэг уран уншигчийг шалгаруулах "Уран жиргээ" тэмцээнийг 4 насны ангиллаар Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийн хооронд 2023 оны 03 сарын 03-ны өдөр Хүүхдийн ордонд зохион байгуулахаар удирдамжийг боловсруулж хүргүүлсэн.

"Хүүхдийн хөгжил, хамгаалалд-үүрэг хүлээгчдийн эрх үүрэг" арга хэмжээг СӨБ-ын багш, сурган хүмүүжүүлэгчид, асран хамгаалагчдад зохион байгуулах: Сайншанд сумын 1,3,4,5,6,8,9,10 дугаар цэцэрлэгийн нийт 213 асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгчдэд нийгмийн бүх орчинд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан

сэргийлэх, гэр бүл дэх хүүхэд хамгааллын талаар мэдлэг олгосон сургалт зохион байгуулсан.

Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх сургагч багш бэлтгэх сургалтын зохион байгуулалтыг хариуцан ажиллах: Монголын Урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоотой хамтран "ҮЕ ТЭНГИЙН СУРГАГЧ, МЕНТОР" бэлтгэх сургалт зохион байгууллаа. Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБС-ын 6-11 дүгээр ангийн сурагчдын төлөөлөлд, Үе тэнгийнхний дээрэлхэлт, ялгаварлан гадуурхахыг бууруулах, хамгаалах, урьдчилан сэргийлэх "Үе тэнгийн сургагч ментор бэлтгэх сургалт"-ыг зохион байгууллаа. Сургалтын дараа ментор сурагчид сургалтаас сурсан мэдлэгээ бусдад хүргэх нөлөөллийн ажлыг хийж, дадлагажиж ажиллалаа. Цаашид сургагч багш нараар дамжуулан үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтын ойлголт мэдлэгийг дээшлүүлэх сургалт нөлөөллийн арга хэмжээг насанд хүрэгч, хүүхдүүдэд хүргэж ажиллахаар боллоо.

Энэхүү сургалтыг зохион байгуулахад аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ-с 1,863,600 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.

ХБХЭМБНХСалбар комиссын хуралд оролцсон: ХБХЭМБНХСалбар комиссын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралд оролцож нийт 27 хүүхдийн асуудлыг авч хэлэлцэн цуцлагдсан 1, шинээр 7 хүүхдийг бүртгэл үүсгэн шийдвэрлэсэн. БШУЯ-ны санаачилгаар зохион байгуулж байгаа боловсролын салбар дахь хүний эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдал, дүн шинжилгээний ажлын хэсэгт тус байгууллагын чиг үүргийн хүрээнд боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал, багш, сурагчид, үе тэнгийн хүчирхийлэлтэй холбоотой түгээмэл гардаг кейс, тулгамдаж буй асуудал, шийдлийн талаар мэдээлэл өгч, харилцан санал солилцсон.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага мэдээллийг хүлээн авч харьяа хамтарсан багт нь шилжүүлэн кейсийн хувийн хэргийн бүрдэлт, судалгаа, шийдвэрлэлтийг тухай бүрт хийх: Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2023 он гарсаар 6 дуудлага мэдээлэл ирсэнээс 1 дуудлага нь харьяалал андуурагдсан тул буцаасан, 1 дуудлагыг хаасан, 4 дуудлага мэдээлэл хяналтанд байна.

Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдэд гэрийн эргэлт зохион байгуулах: Сургуулийн амралт эхэлсэнтэй холбогдуулан гэрийн эргэлтэд хамрагдсан Сайншанд сумын эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 7-8 насны 5 хүүхдэд хичээлийн хоцрогдол арилгах давтлага сургалт, 10-15 насны 11 хүүхдэд математикийн хичээл болон сэтгэлзүйчийн ганцаарчилсан болон бүлгийн сургалт, насан туршийн боловсролын төвтэй хамтран компьютер, давсан урлал, лаан урлалын сургалт дархлааг дэмжих зорилгоор витаминжуулалтын багцад хамруулан хүүхдийн чөлөөт цагийг зөв үр дүнтэй өнгөрүүлэх, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэн ажилласан.

Замын-Үүд сумын Жаргалант багийн зохион байгуулагч Болорцэцэг болон ахлах нийгмийн ажилтан Эрдэнэтуяа нарын хамт тус багийн эрсдэлт бүлгийн, архины хамааралтай 2 өрхөд гэрийн эргэлт хийж заавар зөвлөмж өгч ажилласан. Нэг өрхөд хүнсний тусламж үзүүлсэн.

Хоёр. Залуучуудын хөгжил оролцоо чиглэлээр:

Залуусаа сонсох өдөр арга хэмжээний хүрээнд залуучуудын чөлөөт уулзалт зохион байгуулах; *Залуусаа сонсох өдөр арга хэмжээний хүрээнд "Залуучуудын оролцоо" чөлөөт уулзалтыг 2023 оны 1 сарын 02-ны өдөр зохион багуулж төр төрийн бус байгууллага, өсвөр үе залуучуучуудын 18 төлөөлөлтэй уулзаж 2022 оны дүгнэлт болон 2023 оны төлөвлөгөөг ярилцлаа. Уулзалтын үр дүнд 2 арга хэмжээ, 2 сургалт, номын клуб ажиллуулахаар боллоо.*

"Үе тэнгийнхнээсээ суралцъя" чөлөөт уулзалт зохион байгуулах: Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд залуучуудын хөгжил, оролцоог дэмжиж "Z үеийнхний ярилцлага" чөлөөт уулзалтыг зохион байгууллаа. Уг

уулзалтаар гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт суралцах боломж, бололцоо, сэтгэл зүйн боловсрол болон мэргэжил сонголт, хувь хүний хөгжил зэрэг сэдвийн хүрээнд 21 залуучуудыг хамруулан мэдлэг ойлголтыг өгч ажиллалаа.

Амьдрах ухааны сургалт зохион байгуулах; Хувь хүний хөгжлийн сургалтыг ШШГГ-ын 10 албан хаагчдад зохион байгууллаа.

“Залуусын дуу хоолой” Замын -Үүд сумын залуучуудын нээлттэй хэлэлцүүлэгт оролцох: “Залуусын дуу хоолой” Замын-Үүд сумын залуучуудын нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулагдаж Залуусын үзэл бодлыг сонсож сонирхсон асуултад хариулт өглөө.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажлын байртай танилцах аялал: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголтод нөлөөлөх зорилгоор “Бадрах Энержи” ХХК-тай хамтран “Коже говь” уурхайтай танилцах аяллыг зохион байгуулж төвийн сургуулийн ахлах ангийн инженер, цөмийн физик, геологич, засварчин, гагнуурчин болох сонирхолтой 14 сурагчийг хамруулан зохион байгууллаа. Уг арга хэмжээ нь сонирхсон мэргэжилтэйгээ газар дээр нь танилцаж тухайн мэргэжлийн гоё сайхан болон хүндрэлтэй талуудыг мэдэж авах сонгосон мэргэжлээ лавшруулан судлахад чухал ач холбогдолтой аялал боллоо. Уг аяллын бүх зардлыг “Бадрах Энержи” ХХК гаргалаа.

Зорилтот бүлгийн хүүхдүүдэд зориулан хичээлийн хоцрогдол арилгах болон мэдлэг чадвар олгох үнэ төлбөргүй сургалтууд зохион байгуулах: Зорилтот бүлгийн өсвөр үе залуучуудыг дэмжих зорилгоор Математикийн хичээлийн хоцрогдол арилгах сургалт, компьютерын өргөн хэрэглээний программ болон фотошоп программын хэрэглээний сургалт, 3*3 шооны сургалт, уран бичлэгийн сургалтыг тус тус зохион байгуулж 10-17 насны 40 хүүхдийг хамруулж ажилласан.

Аймгийн Залуучуудын салбар зөвлөлийн төлөвлөгөөний саналыг авах: Аймгийн Залуучуудын салбар зөвлөлийн төлөвлөгөөний саналыг авах албан тоотыг байгууллагуудад хүргүүлж одоогийн байдлаар 4 байгууллага төлөвлөгөөний саналаа ирүүлээд байна.

Уншдаг болГОЁ” номын хэлэлцүүлэг” зохион байгуулах: “Уншдаг болГОЁ” номын хэлэлцүүлэг”-ийг Говийн хөх салхи НҮТББ-ын дэргэдэх Дорноговийн сайн дурынхны төвтэй хамтран өсвөр үе залуучуудыг ном уншдаг болгох, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, номоор дамжуулан нөхөрлөх зорилгоор зохион байгууллаа. Уг номын хэлэлцүүлэг нь сар бүрийн хоёр дахь долоо хоногийн бямба гараг бүр 10 цагаас тогтмол явагдаж байна.

Албадлагын чанартай арга хэмжээ авагдсан хүүхэдтэй ажиллах: Албадлагын чанартай арга хэмжээ авагдсан 3 хүүхэдтэй ажиллаж 3-р сургуулийн Б гэдэг хүүхэдтэй уулзалт хийж түүний давуу тал дээр тулгуурлан 2-р сараас хагас бүтэн сайн бүр “Миний Робот” хүүхдийн сэтгэн бодох дугуйлангийн багшаар ажиллуулахаар боллоо. Мөн У болон М нарын давуу болон сул тал, цагийн менежмент дээр анализ хийж, аймгийн ХХҮГ-ын зарласан мэргэжил олгох түр сургалтад бүртгүүлж, ажлын зарыг танилцуулж ажиллаа.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

БШУГ-ын дарга Сайншанд сумын 1, 2, 3, 5 дугаар сургуульд биечлэн ажиллаж, бусад сумдын сургуулийн удирдлагуудтай онлайнаар уулзалт зохион байгуулж, багш нарт боловсролын шинэчлэл, боловсролын төсөв санхүүгийн шинэчлэл, багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дата анализыг танилцуулж, цаашид байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө зорилго, зорилттойгоор тусган ажиллах тухай сургуулийн удирдлагуудад үүрэг өглөө.

ЕБС-ын 2022-2023 оны хичээлийн жилийн номын сангийн СУ-17, сургалтын орчны БДБ-18 мэдээг маягтын дагуу нэгтгэн боловсролын салбарын системээр илгээж, албан бичгээр холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргэсэн.

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” /2020-2024/ үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд багш нарыг мэргэжлийн хөгжлийн бүлгээрээ хамтран суралцаж, мэдлэг чадвараа хөгжүүлэх зорилгоор сурагчдын амралтаар багш нарын дунд дараах 5 чиглэлээр үйл ажиллагааг зохион байгууллаа.

БШУГ-ын дарга болон судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд /Математик, Гадаад хэл, Технологи, Бага боловсрол, Хүүхэд хөгжил, хамгаалал / хариуцсан мэргэжилтнүүд сургалт зохион байгууллаа.

Аймгийн 21 сургуулийн багш нар 20 судлагдахуунаар агуулга болон үнэлгээний түвшнээр даалгаврын сан бүрдүүлж, байгууллагын цахим санд байршууллаа.

Сургууль бүр багш нарынхаа арга зүйг сурталчилж, хэлэлцүүлэг, илтгэл зохион зохион байгуулсан.

Зөвлөх багш нар аймгийн хэмжээнд сургалт зохион байгуулсан.

- Ц.Батбаяр “Medlee.mn-д цахим контент байршуулах аргачлал”
 - Г.Отгонтуяа “Нүдлэн тогтоолгох аргаар бичих чадварыг хөгжүүлэх арга зүй”
 - У.Баярмаа “Өгүүлбэртэй бодлого бодуулж сургах арга зүй”
 - Л.Эрдэнэзул “Сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй”
 - Б.Даваасамбуу “Мэргэжлийн хөгжлийн бүлгээрээ хамтран ажиллаж буй туршлага”
- У.Оюунтуяа “Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд анализ хийх” сэдвээр сургалт зохион байгуулсан.

-Тэргүүлэх, заах аргач зэрэгтэй багш нарын туршлага арга зүйг сургууль болон аймгийн хэмжээнд сурталчлан, түгээн дэлгэрүүлсэн. Бага ангийн Тэргүүлэх зэрэгтэй- 60, Заах аргач зэрэгтэй - 51 багшийн арга зүйг түгээн дэлгэрүүлсэн.

Мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтарч Монгол хэлний зүйрлэсэн хэлц үгийн утгыг тайлбарлах “Хамтдаа судалъя, хөгжье” үйл ажиллагааг зохион байгуулсан.

Дорноговь аймгийн хэмжээнд Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг судалж, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр- III”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн албан хаагчдын үндэсний бичгийн сургалтын түвшин тогтоох сорилго авч, үндэсний бичгийн цахим бичвэр боловсруулах сургалт зохион байгуулахаар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга Н.Нарангэрэл тэргүүтэй 3 монгол бичгийн багш аймагт зочиллоо.Сургалтад аймгийн төрийн албаны 95 гаруй байгууллагын нийт 380 гаруй төрийн албан хаагч төлөөлөн оролцсон ба сумдын ЗДТГ, төрийн албан байгууллагаас 100 гаруй албан хаагч цахимаар хамрагдсан. “Үндэсний бичгийн цахим бичвэрийн сургалт”-ыг хоёр хэсэг болгон явуулсан бөгөөд архив, бичиг хэргийн ажилчдыг хамруулсан сургалтад 131, монгол бичгийг сонирхон судалж буй төрийн албан хаагчдыг хамруулсан сургалтад 127, цахимаар 80 гаруй албан хаагч оролцож, үндэсний бичгийн цахим хэрэглээ, бичих чадварт суралцаж, дадлага хийлээ.

Бага ангийн багшийн нарын дунд БШУГ-аас "ХАМТДАА ХӨГЖЬЕ" сургалт, хэлэлцүүлгийг МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ багш нартай хамтран зохион байгууллаа. Сургалт, хэлэлцүүлгийг цахим, танхим хослуулан 3 өдрийн турш зохион байгуулахад танхимаар 4 сургалтын менежер, 79 багш, цахимаар 13 менежер, 135 багш, нийт 233 хүн хамрагдаж, " Багаар ажиллах чадвар", "Явцын үнэлгээ хийхийн ач холбогдол", "Шалгуурт суурилсан даалгавар боловсруулах аргагүй", "Нэгж болон ээлжит хичээл төлөвлөх аргагүй", " Сурагч төвтэй идэвхтэй сургалтын аргагүй"-д суралцаж, Байгууллага болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд анализ хийж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж буй байдал, Мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллаж буй арга туршлагаудтай танилцаж, аргагүйн шинэ санаа гаргалаа. Сургалт хэлэлцүүлэгт Сайншанд ерөнхий боловсролын 1, 2, 3, 5, Эрдэнэ ЕБСургуулийн сургалтын менежерүүд болон ЗӨВЛӨХ БАГШ Б.Даваасамбуу, У.Оюунтуяа, Л.Эрдэнэзул, Г.Отгонтуяа, У.Баярмаа, ТЭРГҮҮЛЭХ БАГШ О.Энхзаяа, Д.Оюунтуяа, Ц.Чанцал, Н.Энхбаяр, Х.Бүдхэнд, ЗААХ АРГАЧ БАГШ Г.Амарбаясгалан, Ц.Энхцэцэг, Д.Оюунчимэг нар хамтран ажиллалаа.

ЗЭРЭГТЭЙ БАГШ НАРЫН АРГА ТУРШЛАГЫГ ТҮГЭЭХ “ЗОЧИН БАГШ” үйл ажиллагааг 2023.01.17-27-ныг дуустал зохион байгуулан ажиллаж сургалтын чанарыг ахиулахад харилцан бие биеэсээ туршлага судлан хамтран ажиллаа. Үүнд: Хүүхдийн хөгжлийн хувийн хавтас бүрдүүлэлт, Багшийн аргазүйн сан бүрдүүлэлт, Төсөлт үйл ажиллагааг хэрэгжүүлсэн арга туршлага, Сургалт, үйл ажиллагааны менежмент, FILMORY-X Цахим программ дээр ажиллах аргазүй, Сургалтын төвийн менежмент, Хөгжмийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах аргазүй, Хөгжмийн сургалтын хүүхдийн үнэлгээ, CUBASE программ дээр ажиллах арга зүй, Сэтгэцийн эрүүл мэнд, Зохистой зөв хооллолт ба Эрүүл мэнд, Цэцэрлэгийн манлайлал, менежмент сэдвүүдээр 33 цэцэрлэгийн удирдлага, багш нарт сургалт, хэлэлцүүлэг, дадлага ажлыг зохион байгуулан ажилласан. Мөн дуу хөгжмийн багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлэг, Бага, Дунд, Ахлах, Бэлтгэл бүлгийн Мэргэжлийн хөгжлийн бүлгүүдээ байгуулж, бүлгийн ахлагчаа сонгон, төлөвлөгөөгөө боловсруулан хамтран ажиллалаа.

Тогооч нарыг чадавхжуулах онол, дадлагын сургалтыг 19,20-нд зохион байгуулж сургалтад 18 ерөнхий боловсролын сургууль, Политехник коллежийн нийт 40 тогооч хамрагдав.

“Багаар ажиллах чадвар”, “Идэвхтэй сургалтын арга зүй”, “Сургуулийн менежмент”, “Боловсролын цаг үеийн мэдээлэл” сэдвээр Сайншанд, Айраг, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ, Хатанбулаг, Хөвсгөл, Зүүнбаян, Замын-Үүд сумын ЕБ-ын 1, 2, 3-р сургууль, цэцэрлэгүүдийн хамт олонд сургалт зохион байгууллаа. “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төсөлд хамрагдаж буй Замын-үүд 3, Айраг, Хатанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний орчин нөхцөлд үнэлгээ хийж захирал, тогооч, нярав нартай хамтран ажиллав.

ДӨРӨВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:

- 2023 оны 01 дүгээр сарын байдлаар орон нутгийн төсөвт 6.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 1.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн.
- Шилэн дансны хуулийн дагуу shilendans.gov.mn сайтад сар бүрийн 8-ны дотор төсөв хөрөнгөтэй холбоотой 45 захирамжийг хугацаандаа байршуулж, 2022 оны 4 дүгээр улирлын мэдээллийг илгээсэн. Төсөв хөрөнгөтэй холбоотой 2023 оны 7 захирамж байршуулсан.
- Орон нутгийн байгууллагад 3.4 тэрбум төгрөг, сумдад дэмжлэг 209.0 сая төгрөг, байгууллагуудын тогтмол зардалд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас 1.6 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зардлаас 500.0 сая төгрөг, сумдад өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах зардлаас 591.5 сая төгрөгийн санхүүжилтийг сумдад олгосон.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайланг гаргаж Төрийн аудитын газарт хүргүүлсэн.
- Аймгийн 2023 оны орон нутгийн төсөв, түүний сарын хуваарийг нэгтгэн боловсруулж Сангийн яаманд хүргүүлэн хянуулж, төсвийг Засгийн газрын удирдлагын мэдээллийн системд татуулсан.
- Аймгийн Засаг даргын 2022 оны А/188 дугаар захирамжаар батлагдсан төлөвлөгөөний дагуу сумдын санхүүгийн албаны үйл ажиллагаанд төрийн сангийн дотоод хяналт хийсэн тайланг АЗДТГ-ын даргын 03/38 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

- Засгийн газрын удирдлагын мэдээллийн системд 2022 оны 4 дүгээр улиралд нэвтрэн ажилласан хэрэглэгчийн судалгаа болон тамга тэмдгийн бүртгэлийг нэгтгэж АЗДТГ-ын даргын 03/37 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.
- Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрхийн хүсэлтийг үндэслэн 15 байгууллагын 376.4 сая төгрөгийн зарцуулах эрхийг нээж ажилласан.
- Төрийн албаны цалингийн нэгдсэн системд 2 байгууллагын дарга солигдсонтой холбогдуулан холбогдох эрхийг баталгаажуулсан. Гар утасны төхөөрөмж сольсон, нэг удаагийн нууц үг баталгаажихгүй төлөвт шилжсэн 12 хэрэглэгчийн нууц үгийг дахин сэргээж төлбөр тооцоо хэвийн дамжих нөхцөлийг бүрдүүлж ажилласан.
- 5 аж ахуйн нэгж байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тухайн байгууллагын албан хүсэлтийг үндэслэн засварласан. 2023 онд шинээр байгуулагдсан 7 аж ахуй нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн И-Баланс системд бүртгэн заавар, зөвлөгөө өгч ажилласан.
- Нягтлан бодох бүртгэлийн улсын ахлах байцаагчийн 2022 оны торгууль шийтгэлийн хуудасны тооцоог Хууль зүй, дотоод хэргийн яамны санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Хосбаярт хүргүүлсэн.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь заалтын дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг И-Баланс системд хүлээн авч байна.
- Хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийн Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд 2023 оны 01 сарын 1-31-ний хооронд нийт 640 гүйлгээний 9292.2 сая төгрөгийн төлбөр тооцоог төлбөрийн хүсэлт, хяналтын хуудас анхан шатны баримтын бүрдлийг тулган баталгаажуулж ажилласан.

Статистикийн хэлтэс:

Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:

- Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн 2022 оны 12 дугаар сарын танилцуулгыг боловсруулж, хэлтсийн цахим хуудсанд байршуулан, 600 гаруй хэрэглэгчдэд тархаасан.
- Гол нэр төрлийн 32 бүтээгдэхүүн болон нэмэлтээр 54 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг долоо хоног бүрийн даваа гаригт Сайншанд сумын хүнсний зах, дэлгүүрээс судалж, мэдээний PPI программд шивэн, хугацаанд нь ҮСХ-нд дамжуулсан.
- Сар бүрийн 21-нд хэрэглээний үнийн 313 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг аймгийн төвийн хүнсний зах, дэлгүүрээс судалж программд шивэн, хугацаанд нь ҮСХ-нд дамжуулсан. Айраг, Даланжаргалан, Эрдэнэ, Замын-Үүд, Хатанбулаг сумдаас 145 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг судалж ҮСХ-нд дамжуулсан.
- Аж үйлдвэрийн сарын мэдээ /АҮ-1/, зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны сарын мэдээ /А-3Г-1, А-3Б-1/, тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмжийн импортын үнийн судалгаа/ТХХТИҮ/, худалдааны салбар /ХСҮ/, авто, усан замын тээврийн улирлын мэдээ /Т-1/ Мэдээлэл харилцаа холбооны улирлын /МХХ-3, МХХ-4, МХХ-6, МХХ-7/ мэдээ, хөдөө аж ахуйн /ХАА-2, ХАА-3, ХАА-10/ мэдээг сум, аж ахуйн нэгж, иргэдээс цуглуулж нэгтгэн программд шивж ҮСХ-нд дамжуулсан. Төрийн бус байгууллагын улирлын мэдээ/ТББ/, мал эмнэлгийн улирлын мэдээ /МЭ-1/, барилга байгууламж, объектын улирлын мэдээ /ББО/, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн улирлын мэдээ /АЖ/-г графикт хугацаанд нь дамжуулан ажилласан.

Татварын хэлтэс:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:

- Улс ба орон нутгийн төсөвт 3402,1 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.
- Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 5 төрлийн нийт 459 татварын тайлан, 809 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан. 7 хоногийн хугацаанд 70521288 нэгдсэн дуудлагын дугаараар 588 татвар төлөгчдөд Татварын хууль, НӨАТ-ын урамшууллын систем, Цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөө сурталчилгаа хийсэн.
- Дуудлагаар татварын үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ орон нутагт хэрэгжиж 18001288 дугаарын утсаар 1555 татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлсэн.
- Татвар төлөгчдөөс 1800-1288-д ирүүлсэн 13 гомдлыг хуваарилж, 17 гомдлыг шийдвэрлэж баталгаажуулсан.
- Шинээр үүссэн 3 хуулийн этгээдийн мэдээллийг татварын удирдлагын нэгдсэн ситемд бүртгэж, НӨАТ суутган төлөгчөөр 3 хуулийн этгээдийг бүртгэсэн.
- Дорноговь татварын хэлтэс фейж хуудсаар давхардсан тоогоор 55 мэдээ мэдээллийг 318 татвар төлөгчдөд түгээх ажлыг зохион байгуулсан.
- Газар шилжилт хийж байгаатай холбогдуулан газрын төлбөрийн барагдуулалтад хяналт тавьж, 39 татвар төлөгчид газар эзэмших эрхийг шилжүүлж 1,812,110 төгрөгийн татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.
- ХХОАТ болон ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт, хялбаршуулсан горим ашиглан хувь хүний орлогын албан татварын тайлан гаргах сургалтыг 19 татвар төлөгчид зохион байгуулсан.
- ХХОАТ-н хөнгөлөлт, чөлөөлөлт, буцаан олголтын талаар 829 татвар төлөгчид сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч ажилласан.

Орон нутгийн өмчийн газар :

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 10/06 дугаар тогтоолоор 101 төсөл, арга хэмжээний 51,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын ажил батлагдсанаас 40 төсөл арга хэмжээний захиалагчийн эрхийг аймгийн Засаг даргын захирамжаар сумдад шилжүүлсэн.
- 1 дүгээр сарын байдлаар 4 тендер шалгаруулалтын ажлыг цахимаар зарласан.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу худалдан авах ажиллагааны 2022 оны жилийн эцсийн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн.
- 4 сумын орон нутгийн өмчит байгууллагуудын илүүдэлтэй байр талбайг түрээслэх 26 гэрээг хянан баталгаажуулсан.
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 10/12 дугаар тогтоолоор худалдан борлуулахаар шийдвэрлэгдсэн авто машины нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж 9 ширхэг авто машиныг худалдан борлуулахаас 6 ширхэг авто машиныг борлуулагдаж 16,6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Санхүүгийн хяналт, аудитын алба:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:

- Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамжийг гарган аймгийн Засаг даргаар батлуулсан.
- Аймгийн Засаг даргын “Аргачлал батлах тухай” 2022 оны А/675 дугаар захирамжид тусгагдсан тайлан мэдээний дагуу стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн

биелэлт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны тайлан, өргөдөл, гомдол шийдвэрлэлт, хариутай бичиг, үүрэг даалгаврын биелэлтийн тайлан, байгууллагын ил тод байдлын тайлан, хэрэглэгчийн үнэлгээний тайлан, ногоон байгууламжийн тайлан, хог хаягдлын менежментийн талаар хийгдсэн ажил, арга хэмжээний тайлан, цахим шилжилтийн талаар хийсэн ажлын тайланг гаргаж хэрэгжилтийг хангаж ажилласан.

- Алтанширээ сумын төсөвт байгууллагуудын 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын нэг бүрчилсэн акт, шалгалтын тэмдэглэлийг сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нарт албан бичгээр хүргүүлсэн.
- Сайншанд сумын 6 дугаар цэцэрлэг, 3 дугаар цэцэрлэг, 1 дүгээр цэцэрлэг, 2 дугаар цэцэрлэг, 5 дугаар цэцэрлэгийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж байна.
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021, 2022 оны санхүү аж ахуй үйл ажиллагаанд сэдэвчилсэн хяналт шалгалтыг хийж байна.

ТАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжилт
Нэг. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр		
1	Шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, бүртгэл хөтөлж, удирдлагуудад танилцуулан хэрэгжилтэд хяналт тавих	<p>Засгийн газрын 15 тогтоол. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2022.12.07-ны өдрийн 448 дугаар тогтоол - 2022.12.14-ний өдрийн 461 дүгээр тогтоол - 2022.12.21-ний өдрийн 469 дүгээр тогтоол - 2022.12.21-ний өдрийн 470 дугаар тогтоол - 2022.12.28-ны өдрийн 489 дүгээр тогтоол - 2022.12.28-ны өдрийн 490 дүгээр тогтоол - 2022.12.28-ны өдрийн 491 дүгээр тогтоол - 2022.12.28-ны өдрийн 487 дугаар тогтоол - 2022.12.28-ны өдрийн 488 дугаар тогтоол - 2022.12.28-ны өдрийн 495 дугаар тогтоол - 2022.12.28-ны өдрийн 481 дугаар тогтоол - 2022.12.28-ны өдрийн 493 дугаар тогтоол - 2022.12.28-ны өдрийн 499 дугаар тогтоол - 2023.01.04-ний өдрийн 06 дугаар тогтоол - 2023.01.11-ний өдрийн 15 дугаар тогтоол <p>Засгийн газрын хуралдааны 3 тэмдэглэл. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2022.12.07-ны өдрийн 58 дугаар тэмдэглэл - 2023.01.05-ны өдрийн 01 дүгээр тэмдэглэл - 2023.01.18-ны өдрийн 04 дүгээр тэмдэглэл <p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын</p> <ul style="list-style-type: none"> - 12 дугаар сарын 04-ний өдрийн 10/09 дугаар "Сайншанд сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" тогтоол - 10/10 дугаар "Газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай" тогтоолыг тус тус хяналтад авч, бүртгэл хөтөлж, удирдлагуудад танилцуулан, холбогдох байгууллага, хэлтэст хуваарилсан.
Хоёр. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр		
2	Аймгийн ИТХ-аар үнэлүүлсэн АЖХТ, АЗДҮАХ, АХҮЧ-ийн тайлангийн хэрэгжилтийг	Аймгийн ИТХ-аар үнэлүүлсэн АЖХТ, АЗДҮАХ, АХҮЧ-ийн тайлангийн хэрэгжилтийг 12 сарын 31-ний гүйцэтгэлээр болгон тайлагнах файлыг хэлтсүүдэд өгсөн.

	12 сарын 31-ний гүйцэтгэлээр болгон тайлагнах файлыг хэлтсүүдэд хүргүүлэх, нэгтгэл засварыг хийж дуусган баталгаажуулах	Хэлтсүүдээс ирүүлсэн тайланг ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний new.unelgee.gov.mn цахим санд болон эх хувиар нь аймгийн Засаг даргын 2023 оны 01/107 дугаартай албан бичгээр 01 сарын 31-ний өдөр хүргүүлсэн.
3	Монгол Улсын Засгийн газрын гишүүн, сайд нараас аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх (3 гэрээ)	Шадар сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг 90%, Сангийн сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг 98,9%, Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг 93,8%-тай үнэлэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох хэлтсүүдэд тайланг хүргүүлсэн. 2022 онд 18 сайдтай гэрээ байгуулсан бөгөөд тайланг заагдсан хугацаанд хүргүүлсэн.
4	ЗГХЭГ-т 1 дүгээр улиралд хүргүүлэх тайлангийн хуваарийг батлуулан хэлтсүүдэд хүргүүлэх	Аймгийн ЗДТГ-аас 1 улиралд багтаан хүргүүлэх 13 тайлангийн хуваарийг ЗДТГ-ын даргаар батлуулан, 5 хэлтэс, 1 нэгжид хүлээлгэн өгсөн.
5	Шинээр бүртгэгдсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хуваарилалтыг тухай бүрд хийх, тайланг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 5, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж 4, Монгол Улсын хууль 8, УИХ-ын тогтоол 1, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол 5, Засгийн газрын тогтоол 4, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 5, Засгийн газрын албан даалгавар 2, нийт 34 эрх зүйн актын 115 арга хэмжээг аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 25 агентлаг, 14 сумын Засаг даргын Тамгын газар, 4 төсөвт байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын 6 хэлтэс 2 нэгжид хуваарилан, хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн авч, дундажийг 95%-ийн гүйцэтгэлтэй гэж үнэлэн, ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахимд санд болон цаасаар хүргүүлсэн. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт 115 заалтаас 94 арга хэмжээ 100%-тай буюу “Бүрэн хэрэгжсэн”, 19 арга хэмжээ 70%-тай буюу “Хэрэгжих шатанд”, 2 арга хэмжээ “Хугацаа болоогүй/үнэлэх боломжгүй” гэж үнэлэгдсэн.
6	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг хяналтад авч, архивлахад бэлтгэх /14 сум/	Сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн Хяналт-шинжилгээний цахим санд болон цаасаар хүлээн авч, үнэлгээг нэгтгэн, архивлахад бэлтгэсэн.
7	Агентлаг сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дүгнэх ажлын хэсгийг байгуулах, үнэлэх	Агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дүгнэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2023 оны А/53 дугаар захирамжаар байгуулан, агентлаг сумдаас ирсэн тайланг холбогдох хэлтсийн дарга нарт хүргүүлэн ажилласан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, хэрэглэгчийн үнэлгээний тайлангийн үнэлгээг хэлтсээс үнэлэн, ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлж нэгтгэсэн.
8	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтийн	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 57 тогтоолыг хяналтад авч, холбогдох хэлтэс агентлагуудад хуваарилан хэрэгжилтийн тайланг 01

	тайланг хяналтад авах	сарын 15-наар тасалбар болгон хяналтад авсан.
Гурав. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын чиглэлээр		
9	Шинээр томилогдсон болон албан тушаал өөрчлөгдсөн албан хаагчдад хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд ажиллах эрх нээж, арга зүйгээр хангах	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд ажиллах эрх нээж, арга зүйгээр хангасан.
Дөрөв. Төрийн албаны нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр		
10	01 дүгээр сарын ажлын төлөвлөгөө, тайлан, 7 хоног болон сарын ажлыг тайлагнах	01 дүгээр сарын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хяналтад авч ажилласан. 7 хоног болон сарын тайланг нэгтгэн, ТЗУХ-т хүргүүлсэн.
11	Хэлтсийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Хэлтсийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.
12	Хэлтэст ирсэн албан бичгийг бүртгэн, хяналтад авч, хугацаанд нь шийдвэрлэх	Хэлтэст нийт 58 албан бичиг ирснийг бүртгэн, хяналтад авч, хуваарилсан.
13	Монгол бичгийн хичээлийг хэлтсийн албан хаагчидтай хамтран сурах	Монгол бичгийн хичээл болон Хэлний бодлогын зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагдсан. Хэлтсийн 1 мэргэжилтэн шинээр, 2 мэргэжилтэн монгол бичгийг сэргээн давтаж эхэлсэн.
1413	Шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг уншиж танилцах	Монгол Улсын Хяналтын тухай хууль болон Засгийн газраас ирүүлсэн тогтоол, хуралдааны тэмдэглэлийг хяналтад авч танилцсан.
15	Цаг үеийн болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэх	Хэрэглэгчийн үнэлгээний тайлангийн мэдээлллийг хэлтсийн дарга нарт дундын чаатаар дамжуулан өгсөн. Аймгийн Засаг даргаас Засгийн гишүүн сайд нартай 2022 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийн үнэлгээ болон 2023 онд байгуулсан гэрээг хяналтад авч, нэгтгэлийг аймгийн Засаг даргад хүргэсэн. Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Төрийн бүтээмжийн сэргэлт” төрийн албан хаагчдын ажлын байран дээр сургаж дадлагажуулах сургалтад бүрэн хамрагдсан. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд /Алтан төлийн эзэн, аймгийн аварга малчин, Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт/ оролцсон.
16	Бусад	2023 оны 1 дүгээр улиралд багтаан ЗГХЭГ-т хүргүүлэх тайлангийн хуваарийг ЗДТГ-ын даргаар батлуулан, хэлтсүүдэд хүлээлгэн өгсөн. ХАСХОМ-ийг Эрх бүхий албан тушаалтад хүлээлгэн өгч баталгаажуулсан. Хэлтсийн ахлах мэргэжилтэнд баталгаажуулах чиглэлийг өгсөн. 2022 оны үүрэг даалгаврын биелэлт, аймгийн Стратеги төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэргийн хэлтэст хамаарах заалтын хэрэгжилт, 2023 оны сумдын Засаг дарга нартай байгуулах гэрээнд саналыг тус тус холбогдох хэлтэст хүргүүлсэн. Мобиком корпорацитай хамтран ажиллах санамж

	<p>бичгийн ажлынхэсгийн хуралд оролцсон.</p> <p>ЗГХЭГ-аас зохион байгуулсан “Төрийн судалгааны нэгдсэн платформ” сургалтад хамрагдаж мэдээлэл авсан.</p> <p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2022 оны жилийн эцсийн тайланд ХШҮ хийж ХЭЗХ-т хүргүүлсэн.</p> <p>ТЗУХ-ийн Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтний ажлыг хэлтсийн ахлах мэргэжилтэн түр орлон гүйцэтгэж холбогдох 16 тушаал, захирамжийн төсөл боловсруулан батлуулсан.</p> <p>Хэлтсийн ахлах мэргэжилтэн “Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн программ”-д 66 албан хаагчдын мэдээллийг шинэчилсэн.</p> <p>Хөдөөгийн сэргэлтийн ажлын хэсгийн хийсэн ажлын тайлан, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан ажлын тайланг тус тус хүргүүлсэн</p>
--	---

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР